

МОНГОЛД ХААНТ ОРОСЫН КОНСУЛЫН ГАЗАР БАЙГУУЛАХ ҮЕД ЗОХИОСОН ХҮРЭЭНИЙ ГАЗРЫН ЗУРГИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХҮЙ

Хэрээд Ж.Урангуа
Б.Пунсалдулам

Удиртгал

Монгол орон нь хоёрхон хөрштэй билээ. Энэ нь Орос, Хятад хоёр байлаа. Манж нар 1644 онд Хятадыг эзлэн авсанаар Монгол нь манжийн хөрш болсон аж. Ингээд энэхүү өгүүлэлд Халхын Их Хүрээнд 1861 онд Хаант Оросын консулын газар байгуулагдах үед хийсэн нэгэн газрын зургийн тухай өгүүлэхийн ялдамд өгүүлэн буй үеийн Орос-Монголын харилцааны талаар товч хөндлөө. Манж нар Монголыг эрхшээлдээ оруулж аваад, түүнийг гадаад ертөнцөөс битүүмжлэн хязгаарлах бодлого явуулсан юм. Монгол нь зөвхөн хоёр оронтой хөрш байлаа. Умартад Хаант Орос улс байсан бөгөөд түүнтэй харьцахыг ч хориглож байв. Гэвч Орос болон Чин улс худалдааны гэрээ байгуулж, тус хоёр орны худалдааны зам Монголын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх болсон учир оросууд Их Хүрээ хотод өөрийн консулын газрыг нээж улмаар Монголын тус хот нь “цайны зам” гэж нэрлэгдсэн худалдааны замын гол зангилаа газар болон хувирч, Хутагтын хүрээ их хот болох үндэс суурь чухам энэ үед тавигдсан аж.

Орос, Монголын хилийг манж нар тогтоосон нь

Манж нар Монгол орныг¹ эрхшээлдээ оруулж аваад түүнийг гадаад ертөнцөөс битүүмжлэн хязгаарлах бодлого хэрэгжүүлсэн юм. Ар Монгол нь Чингийн эзэнт гүрний хамгийн хойт хил хязгаар болж байсныхаа хувьд тэдний анхаарлын төвд байв. Хойт хил хязгаараа хамгаалахын тулд Монголын хойт хэсгээр гэр харуулыг олноор буй болгож сэргийлэн хамгаалах болсон. Улмаар Монголд гадаадын, түүн дотроо Оросын нөлөө орж ирэхээс ихээхэн болгоомжилж байжээ. Тиймээс ч 1720 онд Хүрээнд² байсан хоёр орос худалдаачныг хөөн гаргаж, Оросоос Монголоор дамжин Хятад руу явах худалдааны цувааг хориглосон шийдвэр гаргахын зэрэгцээ монголчуудыг оросуудтай харилцах явдлыг хатуу хоригложээ. Бидний энд өгүүлэх үйл явдал өрнөхийн өмнөхөн үед холбогдох Оросын нөлөөг Монголд нэвтрүүлэхгүй байх зорилгоор хийсэн олон зүйлсийн талаарх баримтууд өдгөө Монгол Улсын Үндэсний төв Архивд хадгалагдаж байна³. Монголыг Оросоос зааглах

¹ Өмнөт Монголыг 1636, Халх Монголыг 1691, Баруун Монголыг 1755-1757 он

² Богдын Хүрээний тухай сурвалж бичгүүдэд 1639 оноос тэмдэглэж эхэлсэн ба Хүрээ буюу Өргөө нь 1706 онд Сэлбэ голын эрэгт иртлээ хорь гаруй удаа нүүдэллэж улмаар 1778 онд Алтан тэвшийн хөндийд Туул голын эрэгт бүр мөсөн төвхнөсөн гэдэг

³ УТА. Ф.М-1, Д-1. Хн-4689. Оростой элдэв зүйлээр харилцсан, мөн Оросыг сэрэмжлэх тухай

Ж.Урангуа

Монгол улсын их сургууль
uranguakhereid@gmail.com

Б.Пунсалдулам

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн
borpunsaa@yahoo.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

болон умард хилээ битүүмжлэн бататгах Чингийн төрийн анхнаасаа эхлэн баримталж ирсэн бодлого нь 1911 онд Монголчууд тусгаар байдлаа олтол хэрэгжиж байсан амуу.

XVIII зууны эхэн үе хүртэл Орос-Монголын газар нутгийн хилийн дээс шугам хэлбэр төдий байсан юм. Гэвч Монгол орныг эрхшээлдээ оруулсан манж нар Орос-Монголын хилийн дээсийг хуульчлан тогтоохыг шаардсаны дагуу 1727 онд Хиагтын гэрээ⁴ гэгчийг байгуулж Орос-Монголын хилийн дагуу шон босгож хилийн зурвасыг тогтоон харуулууд суулгаж, хил даван гарахад заавал зөвшөөрөл олгодог болсоноос хойш хоёр орны ард түмний чөлөөт харилцаа төгсгөл болсон юм. Эл үед гагцхүү Эрхүүгийн амбан захирагчийн элч 2 түшмэл Хүрэн дэх манж амбан захирагчид Оросын Сенатаас Чингийн Гадаад хэргийн танхимд илгээсэн бичиг захидлыг хүргэн өгөхөөр жилдээ 2 удаа дөрвөн казак цэргээр хамгаалуулан ирдэг байсан ба мөн 10 жилд нэг удаа Бээжин руу шашны номлогчид Хүрээгээр дамжин өнгөрдөг байжээ.

Орос-Монголын харилцааны шинэ үе эхэлсэн нь

1860 онд Орос-Чин гүрний хооронд Бээжингийн гэрээ байгуулагдсанаар Хаант Оросын Монгол дахь худалдааг Чин гүрэн хүлээн зөвшөөрч, мөн Хаант Оросын консулын газрыг Их Хүрээнд байгуулах шийдвэр гарсанаар Орос-Монголын харилцааны нэгэн шинэ үе эхэлсэн юм. Онон, Эргүнэ голоор, Хиагт болон Баруун Монгол руу олон арван худалдаачид, казакууд, мөргөлөөр явах буриадууд гэх мэт янз бүрийн хүмүүс Монголд ирэх болжээ. 1865 он гэхэд Монголд 3977 хүн хүрэлцэн ирж, зарим нь тус оронд амьдрахаар үлджээ.⁵

1860 оны Орос-Чингийн Бээжингийн гэрээ нь 1858 оны Айгуны гэрээ⁶ болон мөн оны Тяньцзинь хэлэлцээрийн⁷ үргэлжлэл бөгөөд тус гэрээ хэлэлцээрүүдээр Хаант Орос болон Чин гүрний хил хязгаарыг тогтоосон болно⁸. Ингээд 1860 онд Бээжин хотноо байгуулагдсан арван таван зүйл бүхий гэрээний 5 дугаар зүйлд зааснаар:

- Оросын худалдаачид Хиагтаас Хүрээгээр дамжин Бээжинд очиж худалдаалахыг

тушаасан хэрэг. 1858 он

- УТА. Ф.М-1, Д-1. Хн-4732. Оростой найрмдлын гэрээ байгуулах мөн Оросыг сэргийлэх тухай тушаасан. 1858.

- УТА. Ф.М-1, Д-1. Хн-4759. Орос улстай найрсагаар бэлэг юм хүргэсэн, тэдэнтэй худалдаалахыг хориглосон ба тэдний түшмэлийн гэрийг олон тасалгаатай бариулахгүй зэрэг бичгүүд. 1860 он

- УТА. Ф.М-1, Д-1. Хн-4844. Орос эмэгтэй хүнийг Хүрээнд оруулахгүй гэсэн ба мөн Орос хүний хүүрийг булуулахгүй гэх зэрэг бичгүүд. 1862он

⁴ 1727 оны Хиагтын гэрээгээр Орос болон Хятадын худалдаачид Хиагт болон Цурхайт (Эргүнэ гол дахь-Ж.У.) гэх хилийн хоёр боомтод л худалдаа хийхийг зөвшөөрсөн байна. Монголчуудыг оросуудтай наймаа хийхийг хориглосон ба монголчууд зөвхөн хятадуудаас юм худалдаж авах ёстой байв. Гэрээний дараа 1728 онд Оросын Троицкосавск цайзаас холгүй худалдааны Хиагт суурин буй болж, тэнд 1851 оноос хилийн комиссар суух болжээ. Хятадын талаас мөн тэнд өөрийн худалдааны төвийг нээсэн нь Маймаачин хэмээн нэрлэгдэх болсон ба Хүрэнээс томилогдсон хилийн асуудал хариуцсан тусгай төлөөлөгч суух болсон байна.

⁵ Н.Е.Единархова. Русские в Монголии: основные этапы и формы экономической деятельности (1861–1921). Иркутск, 2003, стр.5

⁶ Айгуны гэрээ - 1858 оны 5 сард Хаант Орос болон Чин гүрний хооронд Айгунь хотод байгуулсан гэрээ. Амар мөрнөөр Орос-Чингийн хилийг тогтоожээ.

⁷ Тяньцзинь хэлэлцээр-1858 оны 6 сард Хаант Орос улс болон Чин гүрний хооронд байгуулагдсан 12 зүйл бүхий гэрээ. Эл гэрээгээр эл хоёр орны хоорондын найрамдалт байдлыг батламжилж, тус хоёр оронд оршин суух оросууд болон манж-хятадуудын хувийн аюулгүй байдал, өмч хөрөнгийн халдашгүй эрхийг батлан өгчээ. Мөн Оросууд Бээжин рүү элч төлөөлөгч илгээх болон Чингийн зарим боомтуудад Оросын хөлөг онгоцнууд нэвтрэх эрхийг олж авсан байна.

⁸ 1858 оны хоёр удаагийн хэлэлцээрээр Үсүрээсзүүн тийш далай тэнгис хүртэлх нутгийн хил хязгаарыг тогтоогүй байсанг 1860 оны Бээжингийн хэлэлцэлээр тогтоож улмаар 1861 оны Бээжинд хоёр орны хилийн зурвасыг нарийн тогтоож тэмдэглэл хийсэн газрын зургийг үйлдэж, харилцан багалгаажуулжээ. Харин баруун хил хязгаараа тогтоон баталсан хэлэлцээрийг 1881 онд Петербург хотноо хийсэн байна.

зөвшөөрсөн бөгөөд чингэхдээ оросын худалдаачид Хүрээ болон Хаалганы хооронд худалдаа наймаа хийж болох боловч Монголд бөөний худалдааны төв нээхийг хоригложээ.

- Оросын засгийн газар Хүрээнд цөөн хүний орон тоотой консулын газар нээж, өөрсдийн хөрөнгөөр орох байраа барихыг зөвшөөрчээ.

- Хятадын худалдаачид Орост худалдаа наймааны ажлаар зорчиж болно. Гэхдээ нэг удаад 200-гаас илүү хүн явж болохгүй бөгөөд хил нэвтрэх эрхийн бичгийг хилийн асуудал хариуцсан даргаас авах ёстой бөгөөд тэрхүү зөвшөөрлийн бичигт жингийн цувааны ахлагчийн нэр, явж буй хүмүүсийн нэр, явах чиглэл зэргийг тодорхой тэмдэглэсэн байх ёстой. Зам зуур худалдаачид арилжаа наймаа чөлөөтэй хийж болох бөгөөд өөрсдийн зардал сүйтгэлээ хариуцах ёстой гэж заажээ.

Мөн тус гэрээний 8 дугаар зүйлд: Оросын засгийн газар Хүрээ болон Кашгарт консулын газар нээх, мөн Чин улс хүсвэл өөрийн консулын газрыг Хаант Оросын газар нутаг дээр байгуулах эрхтэй. Консул нь өөрийн орны худалдаачдын эрх ашгийг хамгаална. Эрүү, иргэний шинжтэй хэрэг зөрчил гарвал өөрийн орны иргэний эрх ашгийг хамгаална, зугтан оргож орогносон иргэдийг эргүүлэн өгөх үүрэгтэй хэмээн заажээ⁹.

Орос-Монголын хилийн асуудлыг Хүрээн дэх манж амбан¹⁰ хариуцаж, Оросын талаас Дорнод Сибирийн генерал-амбан захирагч гүн Н.Н.Муравьев хариуцах болжээ. Халхын Хүрээнд байгуулж буй консулын газар нь Оросоос Чин гүрний газар нутаг дээр байгуулж буй гуравдахь консулын газар¹¹ нь байв.

1861 оны 6 сард Хүрээнд Оросын консулынхан хүрэлцэн ирсэн байна. Үүнд, консул К.Н.Бобрыкин, нарийн бичиг-орчуулагч Я.П.Шишмарев, эмч И.Осипов, офицер П.Рогалев, 20 казак цэрэг мөн тэднийг дагалдан хэд хэдэн худалдаачин иржээ. Тэднийг манж түшмэдүүд өмнө нь сууж байсан нэгэн хуучин тав тухгүй байранд оруулжээ. Оросын консулын газарт байшин сууцаа барихад зориулан газар олгох асуудлыг 1860 онд Бээжинд хэлэлцээр байгуулаад нутаг буцаж байсан Хаант Оросын элч төлөөлөгч Н.П.Игнатьев Хүрээгээр дамжин өнгөрөхдөө манж амбантай хэлэлцэн¹² Консулын газрыг Их Хүрээний лам нарын Зүүн Хүрээнээс хятадуудын хороолол болох Маймаачны хооронд орших Дунд овоо хэмээх өндөрлөг газарт олгох мөн малаа адгуулах газрыг Улиастай голын орчимд олгохоор товлон хэлэлцэн тохирсон байжээ. Консулын газрын байшин барих болон консулынхны мал хариулах газар олгох асуудал зэрэгт Шишмаревын тэмдэглэснээр манж амбан ихэд хүнд сурталтай хандаж байжээ. Ер нь манж амбан Оросын консулыг төдийлөн найртай хүлээж аваагүй бөгөөд консул түүнтэй анх уулзахаар урихад тэрээр очоогүй бөгөөд оросуудыг өөрсдийг нь яаманд ирж уулзахыг шаардаж байжээ. Мөн Консулын газар төрийн далбаагаа мандуулахад, тугны хэмжээ том бөгөөд хэтэрхий өндөрт мандуулж байна. Түүнийгээ багасга, намсга гэсэн шаардлагыг тавьж байжээ¹³.

Нэгэн эх сурвалжинд дурьдсанаар хэн нэгэн хүн товлосон газрын тухайд манж амбаны хатгаасаар Богд гэгээний нэрийн өмнөөс гэсэн захиаг нэгэн бичээчээр бичүүлж Манжийн

⁹ “Сборник договоров России с другими государствами. 1856-1917 гг. М., Гос. изд-во полит. литературы, 1952, стр. 111

¹⁰ 1762 онд Хүрээнд манж амбан сайдын газар байгуулагдсан. Хүрээнд мөн Халхын хэргийг эрхэлсэн монгол амбан сайд байсан бөгөөд тэрээр анхандаа манж амбанд зөвлөгөө өгөх үүрэгтэй байсан боловч төдөлгүй түүний зааврыг биелүүлэгч болон хувирсан мэт

¹¹ 1851 онд Кульджад Орос болон Чин хоёр гүрний хооронд байгуулсан гэрээгээр Кульджа, Чугучакт Оросын консулын газрыг нээжээ. Гэвч 1862 онд Чингийн баруун хойт мужуудад дунгаанчуудын бослого хөдөлгөөн дэгдэж 1864 онд Дорнод Түркестанд болон Зүүн гарт Чингийн захирагч нарыг хөөн гаргаснаар Оросын консулын газрууд хааджээ. Тус бүс нутаг дахь тэмцэл хөдөлгөөнийг 1878 онд манж нар нухчин дарж, 1884 онд тэнд Чингийн ноёрхол тогтож Шинэжаан (Синьцзянь-шинэ хил) муж болж төв нь Үрүмчи хот болсон.

¹² УТА. Ф.М-1, Д-1, хн-4845, нугалбар 17

¹³ Яков Парфеньевич Шишмарёв. Средневековые исторические источники Востока и Запада. Восточная литература. Цахим эх сурвалж.http://www.vostlit.info/Texts/Dokumenty/Mongol/Sismarev_otcet/framevved.htm

хаанд илгээжээ. Түүнд Оросын консулын газарт олгох гэж байгаа газар нь Богдын өргөөнд хэтэрхий ойрхон байна гэх мэтээр гомдолсон зүйлс бичсэн байжээ¹⁴. Мөн оросууд санааны дураар ой мод цавчин авах явдлыг хориглож, мод хэрэг болвоос Хан уулын Чуулган дарга Түшээт хан Цэрэндоржийн газраас зөвшөөрөл авах ёстой, эсвэл мод худалдаалж буй монголчуудаас худалдан авах ёстой хэмээн шаардаж байжээ¹⁵. Эдгээр баримтаас үзэхэд Их Хүрээнд гадны төлөөлөгч байгууллага буй болж буйд дургүйцэх явдал гарч байжээ.

Консулынхан Хүрээнд ирж амжаагүй байхад Бээжингээс Петербургт Хүрээн дэх консулын байшин 30 цзян (салаа)-тай байх ёстой гэдгийг сануулсан байжээ. Гэтэл гэр бүлийн хамт ирсэн консулынханд энэ нь маш бага хэмжээтэй байшинд бүгд хамт амьдрах нөхцөлийг буй болгожээ. Хоёр давхар байшин баригдаж дуусахын үед байрны хэмжээ хэтрүүлэн барьчихлаа, Оросын тал гэрээний нөхцөлийг биелүүлэхгүй байна хэмээн Бээжин руу мэдээлсэн ба манж амбаны газраас байн байн шалгагч ирж газрын хэмжээг хянаж байсан хэмээн Шишмарев тэмдэглэн үлдээжээ¹⁶.

Оросын консулын газрын 2 давхар байшингийн зургийг офицер П.Роголёв зурж мөн барих ажлыг нь хариуцан хийжээ. Оросын засгийн газар тус байшингийн барилгад нь 1861 оны 8 сард 20 мянган рубль, тавилгад нь 2 500 рубль гарган өгсөн байна. Мөн хожим нь 6 253 руб. нэмж олгосноор Консулын газрын байшинг 1865 онд барьж дуусан ашиглалтанд оруулжээ.¹⁷ Тус байшин нь хоёр давхар модон байшин бөгөөд гадуур нь тоосго өрсөн, байшингийн зүүн талд Сүм¹⁸ байрлаж байжээ.



Хүрээн дэх Хаант Оросын Консулын газар

Оросын Консулын газрын малыг хариулах бэлчээр олгох явдал мөн л хэл амтай асуудал болжээ. Анх Улиастай голын хөндийд 15 газар¹⁹ олгосон боловч Шишмарев тэрхүү газар чулуу ихтэй, халцгай бөгөөд өвс ногоо сахлаг гарахгүй мал адуулахад бэрх тул эл газрыг

¹⁴ Н.Е.Единархова. Дурьдсан зохиол.

¹⁵ УТА.Ф. М-1, Д-1, Хн-4845, н.3

¹⁶ Н.Е.Единархова. Отчеты Я.П.Шишмарева о 25 летней деятельности Ургинского консульства. Иркутск 2001

¹⁷ А.Н.Гаращенко. История строительства русского консульства в Урге в 1861-1866 гг. //Сибирский Архив. 2000, вып.2, с.34

¹⁸ Сүмийг Сибирийн сүсэгтнүүдийн хандивын мөнгөөр босгожээ

¹⁹ Газар-уртын хэмжээ 360 алд буюу 576 метр

өөрчилж ногоо сайн гарах газрыг бодон Хүрээний баруун этгээд Сонгино уулын булан хэмээх газарт шинээр газар олгож өгнө үү хэмээн хүссэний дагуу Сонгинод 12 газрын хэмжээтэй нутгийг Бүрэн засагчийн анхдугаар оны (1861) таван сарын хоринд заан өгчээ²⁰.


Мөн орос хүний хүүрийг Хүрээний газарт булуулахгүй гэх зэрэг учрыг гаргаж Хүрээнд суусан хамаарсан хэрэг барих орос түшмэлд явуулсан нэгэн бичигт: “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд, сайд Сэцэн хан таны бичиг, Их Орос улсаас Хүрээнд суусан хамаарсан хэрэг барих түшмэл Шишмарев дор тушаан илгээв, тушаан явуулах учир, мөнөөхөн харьяат гурван газрын түшмэлээс, Хүрээний зүүн этгээд Дунд овоо хэмээх газрын урьд этгээд ойр газар оросын хоёр хүмүүн газар ухаж буйг үзэж асууваас, тэдний нэгэн үхсэн хүмүүний ясыг энд булмой, хэмээн хэлсэн явдлыг бидний тамгын газар мэдүүлэн ирсэн тухай дор, тэдний улсын үхсэн хүний ясыг манай харьяат газар булваас болохгүй явдлыг түшмэл зарж хэлүүлсэн дор, хамаарсан хэрэг барих түшмэл Шишмареваас гэрээ бичигт манай улсын үхсэн хүний ясыг энд булах явдлыг дурьдсангүй боловч, булваас болохгүй хэмээсэн үг үгүйн дээр, манай улсын хүмүүн аль газарт үхвээс ясыг мөн тэнд булмой, ер уг газарт хойш аваачих ёсон үгүй. Эдүгээ миний захирах нэгэн хүмүүн өвчилж үхсэн явдлыг би мэдмой, сайдууд танаа мэдүүлэх газар үгүй тул, түүний ясыг энд булах учир газар ухуулсан хэмээн хэлж үхсэн хүний ясыг ухсан газарт булсан зэрэг учрыг гаргаж, Зарлигаар Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яамнаа мэдүүлэн явуулсан бөлгөө, эдүгээ Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх шийтгэгч яамнаас хүргэж ирсэн бичигт: Орос улсын үхсэн хүний яс булсан газар болвоос монгол иргэний гэр хөрөнгө тариа тарих газар, жич зам хөөрөг (гүүрийг хэлж буй-Ж.У.) хоосон сул шингистэй газарт холбогдсон харштай газар буй аваас, өөр газарт шилжүүлвээс зохимой. Хэрэв харьяат хэрэг барих түшмэл дагахгүй болвоос, эрхэм сайдын газраас манай яаманд бичиг хүргэж ирүүлээд, Орос улсаас Нийслэл хотод суугаа сайдад явуулаад, уламжилан тушааж дагаж шийтгүүлэе. Жич үүнээс урагш энэ мэт хэрэг буй аваас эрхгүй, харьяат хэрэг барих түшмэлээс тодорхойлон эрхэм сайд танаа мэдүүлээд хянан тогтовоос зохимой. Үгүй аваас дахин уучлахыг хүлээн авч чадахгүйд хүрмой. Хэрхэн шийтгэсэн байдал төлөвийг манай яаманд хариу бичиг хүргэн ирүүлсүгэй хэмээн хүргэж иржэхүй, Байцааваас манай Хүрээний өмнө Хан уул болвоос Их богд эзний дээд зарлигийг хичээнгүйлэн дагаж бидний сайдууд жил бүр хоёр удаа ёслол тахиж, басхүү мод, гөрөөс шувууг өчүүхэн төдий гачигдуулахгүй болгож тусгайлан цаазалж, олон хошуунаас иргэн цэргийн хүмүүн гаргаж цагдан суулгасан их алдартай газар мөн шингистэй дор холбогдмой. Зүй нь олон хүмүүн бүгдээр санаа агуулан эрхэмлэвээс зохих тул, үүнийг Хүрээнд суусан хамаарсан хэрэг барих Шишмаревт тушаан явуулж, Хан уулын ард ойрхон саруул газарт газар малтаж булсан үхсэн хүний ясыг даруй уг газарт аваачуулах, эс бөгөөс өөр үл холбогдох газарт тавих, басхүү Хан уулын ар ойр тойрон газарт Туул голын эрмэгт очиж загас, шувууг агнаваас аль этгээдэд их л тусгүй болох, болзвоос үл болох тул, басхүү харьяат иргэнд ухуулж энэ зэрэг газарт загас, шувуу агнахаар явуулахгүй болго. Жич таны худалдааны иргэд, Хүрээний баруун этгээдэд худалдаалаар суугаа иргэн нарын хашаанд залгамжлан хашаа байгуулж буй явдлыг харьяат гурван газрын түшмэдээс мэдүүлэн иржэхүй. Хянаваас уржинан жил, танай улсын сайд Игнатьев бидний сайдууд танаа нүүр учирч, шинэ тогтоосон гэрээ бичгийн ёсоор Хүрээний газарт хэрэг барих түшмэл суух, басхүү худалдааны иргэд, хойш урагш явахад худалдааны ном тавин суух гэр хашаа байгуулахад газрыг сонгон үзэж, Хүрээний зүүн этгээд Дунд овоо хэмээх нэгэн газар гуч илүү өргөө гэр, хашаа байгуулахыг нэгэнт тогтсондээр, Хүрээний баруун этгээдэд суугаа иргэн нарын гэр хашаа, Жавзандамба хутагтын Хүрээнд нэн ойр, газар нивчүү учирт хүн нэмэн суулгах, гэр хашаа нэмэн байгуулахыг үүрд цаазлах явдлыг Их богд эзэнд айлтгаад зарлиг ёсоор болгосныг хичээнгүйлэн дагаж шийтгэсэн бөгөөд мөн хутагт бурханы хэрэг шийтгэх замд хамаагүй агаад, одоо танай улсын худалдааны иргэд уг тогтсон газар гэр, хашаа байгуулж худалдаалан суух үгүй, харин ч олон худалдааны иргэн нарыг нэмэн суулгах үгүй болгон цаазалсан газар гэр, хашаа байгуулваас болохгүй тул, энэ учрыг хамаарсан хэрэг

²⁰ ТА. Ф.М-1, Д-1, Хн-4845. 3-р бичиг

барих түшмэл ардад ухуулж, Хүрээний баруун этгээд ойр газар байгуулсан гэр, хашааг одооноос даруй татан авч уг тогтоосон газарт хураан байгуулж худалдаалан суулгасугай, жич гэр хашааг байгуулж завдахын инар Хүрээний ойр газар худалдаалах хэмээвээс, бидний улсын олон худалдааны иргэн нарын адил түр модон пин байгуулж өдөр бүр худалдаалах юмыг тавьж үдэшийн цагт хойш татаж аваачуулсугай, басхүү танай улсаас Хүрээнд ирсэн худалдааны ард нарыг хэлэхгүй болвоос манай газарт байцаах бэрх, үүнээс урагш манай гурван газрын түшмэл, танай шинэ ирсэн хүмүүний нэрийг асууваас эрхгүй хэлэх явдлыг хамтаар тушаасугай, үүний тул тушаан илгээв”²¹ гэж оросуудын үйл ажиллагааг хязгаарлаж байсныг тус эх сурвалж харуулж байна

Хүрээний газрын зураг

Оросын консулын газар нээгдэхтэй холбогдуулан 1860 онд оросуудын хийсэн зураг Хүрээн (Урга)-ий²² суурьшлын ерөнхий байдлын зураг ОХУ-ын Эрхүү мужийн Архивт хадгалагдаж байна.²³ Энэхүү зургийг хийсэн зорилго бол Оросын консулын газарт олгогдсон газрыг тэмдэглэн баталгаажуулахад зориулагджээ. Зургийн хуулбарыг Хуурай замын хилийн хамгаалалтын дэд хурандаа М.... батлан гарын үсэг зурсан. Зураг 1:250 000-ын масштабтай.



Зургийн тайлбар: 1.Хутагтын шинэ өргөө. 2. Хутагтын хуучин өргөө. 3. Гол сүм. 4. Майдарын сүм. 6. Гүүшийн газар 7. Зах зээл, 8. Гяндан. 9. Оросуудын хороо. 10. Сэцэн ханы захиргаа. 11. Варьгерын байшин. 12. Хятадуудын сүм. 13. Монгол амбаны байр. 14. Манж амбаны байр. а. Оросын консул. б. Оросын консулын малын бэлчээрийн газар, Маймаачин

²¹ УТА. Ф.М-1, Д-1, хн-4844. 12-р бичиг
²² Монголын Богдын хүрээ нь 1639 оноос **Өргөө** (ᠥᠷᠭᠡᠭᠡ), 1651 оноос **Номын хүрээ** (ᠨᠣᠮ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠡ), 1706 оноос **Их хүрээ** (ᠶᠡᠬᠡ ᠬᠡᠷᠡᠭᠡ), 1912 оноос **Нийслэл хүрээ** (ᠨᠢᠶᠢᠰᠢᠯᠡᠯ ᠬᠡᠷᠡᠭᠡ) хэмээж байгаад 1924 оноос хойш **Улаанбаатар** (ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤ)
²³ Гос. Архив Иркутской области. Ф.24. Оп 11/3, ед.хр.127

зэргийн байрлалыг зураг дээр дүрсэлжээ. Мөн голуудыг тэмдэглэсэн байна.

Халхын Их Хүрээ эл үед хоёр хэсгээс бүрдэж байжээ. Монголчууд амьдарч байсан хэсгийг Богдын өргөө буюу Их Хүрээ, хятадуудын амьдарч байсан хэсгийг Маймаачин гэнэ.

Төр гэрэлтийн 19-р (1839) онд Хүрээг Туул голын хөвөөнд нүүлгэснээс хойш Хүрээний хуучин газар худалдаачид шилжин ирэх урсгал улам эрчимжиж, улмаар мөн Төр гэрэлтийн 22-р (1842) онд нэгэнт тус газарт сууж буй хятад иргэдэд суурьших эрхийг албан ёсоор олгосон байна.²⁴



Их Хүрээн дэх манж амбаны байр

Их Хүрээний түр төрх

Хүрээг Туул голын хөвөөнд суурьшуулснаас хойш V ба VI Богд дараа дараагаар жанч халснаас болж Хүрээний лам нарын дотор Богдын насыг яавал урт болгож чадах талаар багагүй маргаан гарчээ. Банчин Эрдэнийн зөвлөсний дагуу Түгээмэл элбэгтийн 5-р (1855) онд Их Хүрээг дахин Сэлбэ голын хөвөөнд шилжүүлэхэд тус газарт суурьшсан худалдаачдыг Хүрээний зүүн баруун захад газар хуваан олгож нүүлгэжээ. Үүний дүнд Хүрээн дэх Дамнуурчны хэсгүүд бий болох нөхцөл бүрдсэн гэж Японы судлаач Сато Нориюки үзсэн ба тэрээр мөн Хүрээний Дамнуурчин хэсгүүд үүсэн бий болох явц нь хот суурингийн хөгжих ерөнхий жам ёсоор бус, харин тухайн цагийн Хүрээний лам нар, хятад худалдаачид хоорондын онцгой харилцаа болон түүнд хөндлөнгөөс нөлөөлж байсан засаг захиргаа, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалсан хөгжил байсан гэж үзэж байна²⁵.

Маймаачинд 10.000, Их Хүрээнд 12.000 хүн оршин сууж байсны 5 000 нь лам нар бусад энгийн монголчууд, гар урчууд мөн хятад худалдаачид сууж байна хэмээн Оросын жуулчин М.В.Певцов 1879 онд Хүрээнд ирсэнийхээ дараа бичиж үлдээжээ.²⁶

Богдын Хүрээ нь Туул голын ар хөвөөнд, Сэлбэ голын хоёр салааны хөндийд оршиж байв. Өмнө этгээдэд орших Хан уул бол дархан цаазат тахилгатай уул учир харуул

²⁴ Сато Нориюки. Их Хүрээний дамнуурчны хэсгүүдийн тухай. *Northeast Asian Study Series 9*. Center for Northeast Asian Studies. Tohoku University. Sendai, 2006. pp.46-47

²⁵ Сато Нориюки. Манжийн үеийн Халх Монголын хотын судалгаа: XVIII зууны сүүлээс XIX зууны дунд үеийн Хүрээний жишээн дээр. Токио 2009, 423х.

²⁶ М.В.Певцов. Путешествия по Китаю и Монголии. М., Государственное издательство географической литературы, 1951,стр. 45

хамгаалалтай байв. Тус уулын арын бэлд Их тэнгэрийн амнаас Бага тэнгэрийн амны хооронд орших хадан дээр Энх Амгалан хааны (1661-1722) зарлигаар бичсэн “Тэнгэрийн хүчин, суу залийн ивээлд” гэсэн монгол бичээс байдаг нь тэр үед алсаас ч уншигддаг байжээ²⁷. Туул гол нь 32-54 метрийн өргөнтэй, зарим газраараа их гүнзгий байв. Зарим газар 2 салаа болон урсаж, арал үүсгэдэг. Тийнхүү салаалсаныг нь Дунд гол хэмээн нэрлэдэг. Хотын умард хэсэгт Гүнт гэх уултай, уулын өмнөт хэсэг нь ой модгүй. Гүнт нь Хэнтийн нурууны баруун хэсэг юм. Тус нурууны Хүрээгээс баруун зүгт 160 км орших уулын нуруунаас Туул гол эх авдаг. Туул голд олон төрлийн загастай.

Их Хүрээ нь далайн түвшнээс дээш 1300 гаруй метрийн өндөрт орших учир маш цэнгэг агаартай эрүүл уур амьсгалтай.

Хутагтын Хүрээ нь Баруун, Зүүн хэмээн хоёр хэсэгт хуваагдана. Оршин суугчдын ихэнх нь лам нар байв. Тэд монгол гэрт амьдарна. Зүү хэсэгт нь Богдын өргөө, гол гол хийдүүд байх бөгөөд лам нарын хорооллоос гадна хүрээ харчуулын хороо байв. Богд гэгээнтэний өвлийн орд Гандангаас²⁸ өмнө зүгт оршино. Зуны 7-р сард Наадам хийж мөн Майдар бурхан эргэх ёслол болж түүнд 100 гаруй мянган хүн хүрэлцэн ирдэг байжээ. Өвөл сар шинийн баяр мөн өргөн дэлгэр болдог байв. Оросоос буриадууд мөргөлөөр ирж, баяр наадамд оролцоно. Их Хүрээний баруун хэсэгт хятад гар урчууд, ажилчид амьдардаг бөгөөд тэдний дэлгүүр хоршоонууд байжээ. Энд мөн 1879 он гэхэд оросуудын 9 дэлгүүр буй болжээ. Гүнт уулын энгэрт оршуулгын газар байсан. Монголчууд нь нас барсан хүнээ ил тавьдаг байсан. Их Хүрээ, Маймаачин хоёрын дунд Оросын консулын газар оршино. Маймаачин хотын (Амгаланбаатар) 10.000 оршин суугчидын ихэнх хятадууд боловч тэндэхийн пүүсүүдэд ажилладаг монголчууд мөн тэнд амьдарч байжээ. Худалдаачид, гар урчууд бүтээгдэхүүнээ хөдөө хошуу нутаг руу илгээж, өргөн хэмжээний үйл ажиллагаа явуулж байв. Ногоо тарин амьдардаг тариачид, оёдолчид ч байсан байна. Байшингууд нь жижиг хэмжээтэй бөгөөд шавар, зарим нь тоосгон, хашаа нь модон байв.

Оросуудын хийсэн газрын зургаас бид Хүрээнд байсан манж амбаны газар, шорон, монголчуудын шүтээний газар, суврагнууд, уушийн газар, хятадын мөргөлийн газар, Сэцэн хан аймгийн захиргаа, монгол амбаны байр, оросуудын хороолол, зах зээлийн газар, Хутагтын шинэ, хуучин орд зэрэг нь чухам яг хаана байралж байсныг мэдэж авч болж байна.

Их Хүрээний хил хязгаарыг тогтоосон нь

XIX зууны хоёрдугаар хагасаас Их Хүрээ нь бүрэн суурьшлын төв болжээ. Хүрээ нь Их Хүрээ хэмээн нэрлэгдэх болж зөвхөн шашны төдийгүй засаг захиргаа, соёл, зах зээлийн томоохон төв болж хувирсан байна. Тиймээс ч Хүрээнд дэг журам сахиулах үүднээс 1857 онд тусгай дүрэм гаргаж Их Хүрээний орчин тойрон газрыг сэргийлэх явдлыг чангатгах арга хэмжээнүүд авсан байна. Мөн Хүрээний төв болон зах хязгаарыг албан ёсоор тогтоожээ. Энэ нь 1866 онд холбогдоно. Чингэхэд Хүрээний төв дундыг Шар Хүрээ²⁹-ний өмнөх хаалганы өмнө этгээд ойрхон газар цаг улирлын тооны 24 зүгт³⁰ зүг чиг үзэх толь тавьж нийлүүлэн, зогсолтоос:

- Эебэрхийн зүгт эрсэлэн Түшээт хан, Сэцэн хан хоёр аймаг,
- Улаанаас харын³¹ зүг эрслэж Түшээт хан аймаг, Шавь,
- цагаагчинаас хөхөгчиний зүг эрслэж Сэцэн хан аймаг, Шавь

гэж тийнхүү цагдан байцаах газрын завсар болгон хувааж Хүрээний гадуур эргэх замаас

²⁷ М.В.Певцов. Путешествия по Китаю и Монголии. М., Государственное издательство географической литературы, 1951, стр. 46

²⁸ Гандантэгчилэн буюу “Төгс баясгалант их хүлэн” хийд 1838 онд V Богд Жэвзундамба хутагтын байгуулагдсан. Мөн “Баруун хүрээ” хэмээн нэрлэгдэнэ.

²⁹ Богдын шар ордонг хэлж байна. Зүүн Хүрээнд байрлана.

³⁰ Дөрвөн зүг, дөрвөн зовхис, найман өнгө, найман өнцөг бүгд 24 хувиараас бүтсэн бэлэгдлийг монголчууд өнгө, зүг чиг, тоо, цаг, амьтны болон махбодын (зургаан) зүйлд хэрэглэдэг уламжлал буй

³¹ Өмнө зүг-улаан, хойт зүг-хар, зүүн зүг-хөх, баруун-цагаан, төв-шар өнгө гэх аж.

үүсгэн 360 алдыг нэгэн газар, 36 алдыг нэгэн хувь болгон хэмжиж Эбэрх хөхөгчин гурван зүгийн хэмжээний нэгэн газар тутам нижгээд тэмдэг хатгаж гагцхүү 15 газрыг тэмдэг овооны модонд үсэг, бусад 21 зүгийг мөн гадуур эргэх замаас үүсгэн хэмжиж 5 газрын эцэст тус бүр модоор овоо тэмдэг босгож хил хязгаараа тогтоон авчээ³². Энд дурьдсан 15 газрыг хэмжээний нэгж болгон, түүнийг сэргийлэх цагдаа суулгаснаар “Арван тавны цагдаа” гэдэг хэллэг үүсчээ. Арван тавны цагдаа нар Их Хүрээний ойр орчмын эргэн тойрон газрыг цаг ямагт цагдан манаж Хүрээнийхний амгалан тайван байдлыг сахиулах үүрэгтэй байжээ. Цагдаа нар нь Түшээт хан, Сэцэн хан, Шавь зэргийн суман ардууд бөгөөд тэдний зардал сүйтгэлийг нь харьяат тухайн аймаг нь хариуцдаг байжээ.

Их Хүрээний эдийн засгийн хөгжил

Ингээд Их Хүрээнд Хаант Оросын консулын газар байгуулагдаж Орос, Хятадын худалдаа Монголоор дамжих болж Хиагтаас Хүрээгээр дамжин хоёр тийш худалдааны жингийн цуваа явах болсон нь Хутагтын Хүрээ нь худалдааны замын гол зангилаа боомт хот болон хувирах үйл явц чухам энэ үеэс эхлэсэн юм. 1861 онд Их Хүрээгээр дамжин 168 167 рубль 86 копейкны бараа таваар нэвтэрсэн бол 1862 онд 216.633 руб. 65 коп., 1863 онд 229.868 руб. 6 коп. болж, жилээс жилд өсөн нэмэгдэж байжээ.

Их Хүрээ нь зөвхөн Монголын бурхан шашны том төв төдийгүй, худалдааны их зам дээр орших хот болон төлөвшин тогтох үйл явц чухамдаа бидний өгүүлэн буй үед холбогдох аж. Тус хотод Халхын зүүн хоёр аймаг болох Сэцэн хан, Түшээт хан мөн Богдын Их Шавийн захиргаа оршиж байсан учир засаг захиргааны төв болж байсан амуй.



Их Хүрээний буудалсан цайны жинчид Хиагт руу хөдлөхийн өмнө

³² УТА. ФМ1, д1, хн 5007, нугалбар 20



Их Хүрээнд хүрэлцэн ирсэн жинчид

Дүгнэлт

1860 онд Монголд Оросын консулын газар байгуулагдахад хийгдсэн Их Хүрээний газрын зураг нь түүхийн чухал эх сурвалж юм. Түүнээс тус хотын XIX зууны үеийн дүр төрх, байгууламжуудын байршил, суурьшил, физик газар зүй зэргийн талаар тойм мэдээлэл олох боломжтой. Их Хүрээ нь Монголын шарын шашны тэргүүн хутагт оршин суух газар байснаа улмаар худалдаа арилжаа, засаг захиргааны томоохон төв болох үйл явц чухамдаа өгүүлэн буй үеэс эрчимтэй явагдах болжээ. Худалдааны том зам дээр, зангилаа хэсэгт оршиж байсан явдал нь хойшид Монголын хамгийн том хот болон төлөвшихөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь байжээ. Хожим нь Их Хүрээ нь 1911 оны үндэсний хувьсгалын ялалтын гол төв болж улмаар 1912 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарласан Олноо өргөгдсөн Монгол улсын Нийслэл хот болсон билээ.

SUMMURY

Mongolia has two neighbouring countries as Russian and China, but after Manchu conquered China in 1644, Manchu had been our neighbor for quite a long time. Manchu or Qing dynasty set the borders of Russia and Mongolia and Manchu's policy on Mongolia was subduing Mongolia and separating it from external world.

But after signing a trade agreement between Russia and Qing dynasty in 1860, Mongolia became the trade crossroad between these two states and the trail was named as a "tea road". Then Russia opened its consulate at Urga and the new era of relationships between Russian and Mongolia was started.

In the paper, along with stating about a map which was made at the time when the consulate of Russian Kingdom was set up in Khalkh's Ikh Khuree – Urga in 1861, we wrote about relationships between Russia and Mongolia at that time period.

The map of Khuree that is shown here demonstrated the locations of rivers and the places as 1. Хутагтын шинэ өргөө. 2. Хутагтын хуучин өргөө. 3. Гол сүм. 4. Майдарын сүм. 6. Гүүшийн газар 7. Зах зээл, 8. Гяндан. 9. Оросуудын хороо. 10. Сэцэн ханы захиргаа.

11. Варьгерын байшин. 12. Хятадуудын сүм. 13. Монгол амбаны байр. 14. Манж амбаны байр. а. Оросын консул. б. Оросын консулын малын бэлчээрийн газар, Маймаачин.

Starting from the mid XIX century Khuree became the center of full settlement and special regimes and regulations for its security and bordering were set up. Since it was the trade crossroad between two big nations, its economic development was strengthened, too.

The map of Khuree made at the time when Russian consulate was established in Mongolia in 1860 is a significant source of history. It can give rough data on the outlook of the city in the XIX century, locations of its constructions, its settlement and its physical geography. The fact that Khuree was located at the junction of trade acts influenced its development into the largest city of Mongolia. Later in 1911, Khuree became the center of Mongolian national revolution and then in 1912 it became the capital of an independent Mongolia.